



Европын
Комисс

Түншүүд сайн сайхан ирээдүйн төлөө

ЕХ, түүний гишүүн орнууд
ба Монгол Улсын хоорондын
хамтын ажиллагаа

Олон улсын
хамтын ажиллагаа
ба хөгжил

ТҮНШҮҮД САЙН САЙХАН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ:

ЕХ, түүний гишүүн орнууд ба Монгол Улсын хоорондын хамтын ажиллагаа

Европын Комисс
В-1049 Брюссель

Европын Холбооны тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг интернэтээс авах боломжтой (<http://europa.eu>).

Хэвлэл	ISBN 978-92-9238-347-3	doi:10.2871/163986	ZH-02-16-216-MN-C
PDF	ISBN 978-92-9238-346-6	doi:10.2871/331210	ZH-02-16-216-MN-N

Люксембург: Европын Холбооны Хэвлэлийн төв, 2016

© Европын Холбоо, 2016

Эх сурвалжийг дурдсан тохиолдолд хэвлэн, олшруулахыг зөвшөөрөв.

Товхимлыг Англи, Монгол хэлээр нийтлэв. Европын Комисс болон Европын Комиссын нэрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэгч хэн нэгэн энэхүү мэдээллийг ашигласан аливаа үйлдэлд хариуцлага хүлээхгүй.

Бельгид хэвлэв

Хлоргүй цайруулсан цаасан дээр хэвлэв (ECF)



Европын Холбоо (ЕХ), түүний гишүүн орнууд болон Монгол Улсын хооронд бий болсон бат бэх хамтын ажиллагааны талаарх энэхүү танилцуулгыг толилуулж байгаадаа би ихээхэн баяртай байна. Танилцуулга маань нийгмийн бүхий л түвшинд, олон арван салбарт бий болсон харилцаа, холбооны талаар ойлголтыг өгөх юм.

Монгол Улс бол Төв Ази дахь ардчиллаа түнхагласан цөөхөн орнуудын нэг. Байгалийн асар их баялгаа ашиглахын хэрээр, энэ улс сүүлийн арваад жил маш хурдацтай өөрчлөгдсөн. Тус улс олон талт хамтын ажиллагааны

хэд хэдэн байгууллагад чухал үүрэгтэй оролцдог бөгөөд нийслэл Улаанбаатар хотдоо 2016 оны Ази, Европын дээд түвшний үүлзалтыг (АСЕМ) зохион байгуулж байна.

Монгол Улс нь ЕХ, түүний гишүүн орнуудтай байгуулсан түншлэлийн харилцаагаа хөгжүүлснээр шинэ шинэ сорилтуудыг давж гарах чадвартай болохын зэрэгцэн ноу-хау, үр чадвар харилцан солилцох замаар цэцэглэн хөгжих болно. Монгол Улс нэмүү өртөг шингэсэн, төрөлжсөн эдийн засагтай болж байгаа нь өсөлттэй, шинэ зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортлох хүсэлтэй Европын бизнес эрхлэгчдийн хувьд ч сайн мэдээ юм. ЕХ-Монгол Улсын хөгжлийн хамтын ажиллагааны 2014-2020 оны хөтөлбөр нь тус улсын уул уурхайн салбарын тэсрэлтээс бий болсон боломжуудыг эдийн засгийг төрөлжүүлэх, тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг бий болгох зэрэг өргөн цар хүрээтэй ажил болгоход чиглэгдэж байна.

ЕХ, түүний гишүүн орнуудтай байгуулсан түншлэл нь соёл уламжлалаа хамгаалах, соёлын солилцоо хийх, Монгол Улсыг тогтвортой ардчилсан улс болоход ч дэмжлэг болно. Түншлэлээр дамжин олон арван салбарт, бүхий л шатанд хамтран ажиллах асар их боломж нээгдсэнийг товхимолд онцолсон олон салбарыг хамарсан төслүүдээс харах болно.

Өвөрмөц энэ улс урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд ЕХ, түүний гишүүн орнуудтай хэрхэн хамтран ажиллаж байгаа талаар энэхүү танилцуулга маань тодорхой ойлголт өгнө гэдэгт найдаж байна.

ХАНС ДИЙТМАР ШВАЙГУТ

Европын Холбооноос Монгол Улсад сүүгаа Элчин сайд

Агуулга

Монгол Улс – ЕХ хоорондын түншлэл	3
--	----------

ЕХ, түүний гишүүн орнууд – Хөгжлийн хамтын ажиллагааны салбарууд	9
---	----------



Боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд	10
--	----



Байгаль орчин, тогтвортой эрчим хүч	13
-------------------------------------	----



Уул уурхай, дэд бүтэц	16
-----------------------	----



Бизнесийн хөгжлийн дэмжлэг	19
----------------------------	----



Хөдөө нутгийн хөгжил	22
----------------------	----



Засаглал ба иргэний нийгэм	25
----------------------------	----

ЕХ-ны гишүүн орнуудын Монгол Улс дахь төлөөлөл	28
---	-----------



Монгол Улс – ЕХ

Түншлэл




ЕХ Монгол Улстай харилцах харилцаа

ЕХ, түүний гишүүн орнууд Монгол Улстай тогтоосон уламжлалт хамтын ажиллагаанаас гадна эдийн засгийг төрөлжүүлэх, засаглалыг сайжруулах, соёлын харилцааг бэхжүүлэх зэрэг асуудлыг багтаасан улам ойр дотно харилцааг эрэлхийлж байна. Монголд төлөөлөл нь байдаг ЕХ-ны гишүүн орнуудын ихэнх нь Монгол Улстай 50 гаруй жилийн өмнө дипломат харилцаа тогтоосон байдаг ба энэхүү харилцаа нь 2013 онд гарын үсэг зурсан Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрээр үлэмж өргөжсөн. Түүнчлэн тогтвортой хөгжил, сайн засаглалын Хөнгөлөлтийн ерөнхий системд (GSP+) 2006 оноос хамрагдах болсон Монгол Улс ЕХ-нд гаргах экспортоо нэмэгдүүлэхийн тулд тарифын хөнгөлөлттэй нөхцлийг бүрэн дүүрэн ашиглахыг зорьж байна. ЕХ Монгол Улсын худалдааны гурав дахь том түнш.

ЕХ, Монгол Улсын харилцаа 1989 оноос хойш хурдацтай хөгжиж ирлээ. Европын Комиссоос 2014-2020 онд үзүүлэх хөгжлийн туслалцаанд зориулах зөвхөн буцалтгүй тусламжийн хэмжээ 85 сая евроотэй тэнцэж байна.

Түүнчлэн ЕХ-ны гишүүн хэд хэдэн орон тодорхой салбаруудад тодорхой бүтэц, санхүүгийн хэрэгсэл тухайлбал буцалтгүй тусламж, зээлийн хэлбэрээр хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Жишээлбэл, Европын хамгийн том донор болох Герман Улс дээрх санхүүгийн механизмуудыг хослуулан төрөл бүрийн төслүүдийг хэрэгжүүлж байна. Болгар, Бүгд Найрамдах Чех Улс, Франц, Герман, Унгар, Их Британи гэсэн зургаан гишүүн орон нийслэл Улаанбаатар хотод өөрсдийн Элчин сайдын яамаа ажиллуулж байна. Бусад гишүүн орнууд Улаанбаатартай харилцах харилцаагаа Бээжингээс хавсран явуулж байна. Жирийн иргэд болон засгийн газрын түвшинд аль алинд нь эерэгээр нөлөөлөх хоёр талын арга хэмжээнүүд, тухайлбал соёлын солилцоо гэх мэт үйл ажиллагаанд гишүүн орнууд оролцсоор байна.

Хөрөнгө оруулалт, мэргэшил, дамжуулан эзэмшүүлэх үр чадварыг Монголд нэвтрүүлэхэд Европын бизнес эрхлэгчид шийдвэрлэх үүрэг гүйцэтгэхийн сацуу боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын хүчин чадлыг дээшлүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулсаар байна. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) Монгол оронд байгалийн нөөц баялгаа ашиглах боломжийг олгож байгаа бол, Европын төрийн бус байгууллага (ТББ), агентлагуудын хэрэгжүүлж байгаа төслүүд ноолуур гэх мэт уламжлалт бүтээгдэхүүнүүдэд экспортын шинэ зах зээлийг нээж өгч байна.





ЕХ, түүний гишүүн орнуудын санхүүжилтээр – буцалтгүй тусламж болон зээлээр – хэрэгжиж байгаа хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийн төсөв 190 сая евро давсан байна (2015 онд). Түүнээс гадна, ЕХ, түүний бүх гишүүн орнууд олон талт санхүүгийн байгууллагуудаар дамжуулан Монголд хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагаанд үлэмж хувь нэмэр оруулдаг. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк 2006 оноос хойш Монголд 1.4 тэрбум гаруй еврогийн зээл олгоод байгаа ба Европын Хөрөнгө Оруулалтын Банкнаас Улаанбаатар хотын хөгжилд зориулж санхүүжилт хийж эхлээд байна.

Тогтвортой ирээдүйд чиглэсэн Монгол Улсын алсын хараа

Хөх тэнгэрийн орон гэгддэг Монгол Улс дэлхий нийтийг хамарсан шинэ түншлэл тогтоон хөгжүүлэхийг ихээхэн эрмэлздэг ба түүний “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлого нь дэлхийн олон оронтой хоёр талт болон олон талт дипломат харилцааг хөгжүүлэх боломжийг олгодог. Үүний үр дүнд ЕХ, түүний гишүүн орнууд чухал түншүүд болж ирж байна. Тухайлбал, Монгол Улс Европын норм, стандартуудыг нэвтрүүлж эхлээд байгаа ба эдгээрийг аж үйлдвэр, барилгын салбарт хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Уул уурхайн салбараас улбаатай гайхмаар өсөлтийг үзүүлсэн энэ улс өндөр чанартай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд эдийн засгаа төрөлжүүлэхийг зорьж байна. Монгол Улс шинэ зах зээл бий болгох, дэлхийн эрэлт шаардлагад нийцэхүйц үр чадвартай ажиллах хүчнийг бэлтгэж хөгжүүлэхийг ч зорьж байна.

Хамгийн чухал нь, Монгол Улс урт хугацааны ирээдүйгээ харж төлөвлөж байна. Эдийн засгийг гадны эрсдэлээс хамгаалах бие даасан сан байгуулсан, мөн эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн хөгжил, ногоон хөгжил, засаглалд чиглэсэн – Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 – хөтөлбөрөө баталсан. ЕХ, түүний гишүүн орнууд Тогтвортой хөгжлийн зорилгуудаа (SDGs) хэрэгжүүлэхэд нь Монгол Улсад дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна.



ЕХ-ны тухай товчхон

ЕХ нь энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн төлөө ажилладаг нэгдсэн институцуудын нэгдэл бүхий ардчилсан 28 улсаас бүрдсэн холбоо юм. 1958 онд байгуулагдсанаасаа хойш, ЕХ гишүүдийнхээ тоог нэмэгдүүлсээр институцийн өвөрмөц бүтэцтэй болсон. ЕХ нь төлөөллийн ардчиллын зарчмаар явдаг бөгөөд Холбооны түвшинд иргэд нь Европын Парламентад шууд төлөөлөлтэй, гишүүн орнууд нь Европын Зөвлөлд төлөөлөлтэй байдаг. Европын Комисс нь ЕХ-ны гүйцэтгэх байгууллага юм. Энэ нь ЕХ-ны улс орнуудын засгийн газруудаас хараат бус, Европын нийтлэг эрх ашгийн төлөөх байгууллага. Европын Гадаад Харилцааны Алба (EEAS) нь ЕХ-ны гадаад харилцааны асуудлыг хариуцсан дипломат алба юм.

ЕХ-ны байгууллага болох Европын Хөрөнгө Оруулалтын Банк (EIB) нь Люксембург хотод төвтэй бөгөөд ЕХ дотроо бага хөгжилтэй бүс нутгуудад зээл болон зээлийн баталгаа олгож, бизнес эрхлэгчдийг илүү өрсөлдөх чадвартай болоход нь тусалдаг.

Европын Холбоо, гишүүн орнуудын хамтаар дэлхийн хамгийн том донорын төлөөлөл болдог. Энэ үүргээ үр бүтээлтэй гүйцэтгэхийн тулд үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллага, бусад донор байгууллагуудтай түншлэн нийтлэг асуудлаараа хамтран ажилладаг.

Монгол орны тухай товчхон

Монгол бол өнө удаан жилийн, бахархам түүхтэй орон ба Европын хөгжилд нөлөөлөх үүрэг гүйцэтгэсэн. Өнөөдөр тус улс дэлхийн хамгийн залуу, эрч хүчтэй ардчилсан орнуудын нэг болоод байна. Ардчилал бага хөгжсөн бүс нутагт Монгол Улс ардчиллын жишиг болсоор байна.

Эртний нүүдэлчдийн соёлын өвтэй Монгол орон газар нутгийн хэмжээгээр далайд гарцгүй орнууд дундаа хоёрт ордог ба өвөрмөц, онгон зэрлэг байгальтай энэ газар нутагт 3 сая хүн амьдардаг. Байгалийн баялгийн ашиглалт тус улсын эдийн засагт чухал нөлөөтэй. Монгол бол мөн залуу орон, нийт хүн амынх нь 59% нь 30-аас доош насныхан. Өнөөдрийн байдлаар нийт хүн амын талаас илүү хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна.

"Монгол бол эртний арвин өвтэй, ижилгүй сайхан соёлтой, хосгүй гоёмсог байгальтай орон билээ. Энэ нутагт эрх чөлөөт, эрэлхэг зоригт, энхийг эрхэмлэгч, эрэмгий зүтгэлт ард зон аж төрөн суудаг юм."

Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн Элбэгдорж
2014 оны 10-р сарын 20
Төв Европын Их сургууль
дээр хэлсэн үгнээс

Монгол Улс дахь байнгын төлөөлөл

ЕХ-ны гишүүн зургаан орон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод Элчин сайдын яамаа ажиллуулж байна.

> Болгар

Болгар Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг 2015 онд тэмдэглэсэн. Болгар Улсын Ерөнхийлөгч Росен Плевнелиевийн 2015 оны 5-р сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хөдөө аж ахуйн салбарт техникийн туслалцаа үзүүлэх, боловсролын салбарт тэтгэлэг олгох чиглэлээр хоёр талын хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан байна.

> Бүгд Найрамдах Чех Улс

Бүгд Найрамдах Чех Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг 2015 онд тэмдэглэсэн. 1996 оноос хойш, БНЧУ хөгжлийн хамтын ажиллагаанд зориулж Монгол Улсад 43 сая орчим евро зарцуулсан.

> Франц

Франц Улс Монгол Улстай дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойгоо 2015 онд тэмдэглэсэн бөгөөд хоёр талын түншлэлийн гол салбарууд нь эрчим хүч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл юм. Хоёр талын харилцааг бэхжүүлэх зорилгоор 2012 онд Элчин сайдын яаманд Эдийн засгийн хэлтэс бий болгосон.

> ЕХ-ны бусад гишүүн орнууд

ЕХ болон ЕХ-ны гишүүн бусад орнуудын ихэнх нь Монгол Улстай дипломат харилцааг Бээжингээс хавсран явуулдаг. **Польш** Улс саяхан Монголыг хариуцсан Элчин сайдаа Варшав хотноо томилсон. **Нидерланд** Улсаас Монголын асуудлыг хариуцсан Худалдаа, эдийн засгийн ажилтан Улаанбаатар хотноо ажилладаг. **Итали** Улс ЭСЯ-аа удахгүй нээхээр ажиллаж байна.

> Герман

Герман, Монголын харилцаа 1974 оноос эхтэй бөгөөд энэ үеэс хойш Герман Улс нь Монгол Улсын хөгжлийн хамтын ажиллагааны гол түншүүдийн нэг болсон. 1992 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд, албан ёсны хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд 620 сая гаруй еврогийн дэмжлэгийг үзүүлээд байна. Ашигт малтмалын тогтвортой менежмент, Эрчим хүчний үр ашиг, Биологийн олон янз байдал гэсэн эн тэргүүний гурван чиглэлд төслүүд хэрэгжүүлж 127 сая еврогийн дэмжлэгийг одоогоор үзүүлж байна.

> Унгар

Унгар Улс Элчин сайдын яамаа 2015 онд дахин нээсэн. 2016 оны 1-р сард Унгар Улсын Ерөнхий сайдын хийсэн албан ёсны айлчлалаар хоёр улсын харилцаа шинэ түвшинд гарсан.


> Их Британи

Их Британи 1963 онд Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд өдгөө хавтгай нутагшуулах, зэрлэг амьтдын хууль бус наймааг зогсоох, байгаль орчны чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын чадавхийг дээшлүүлэх зэрэг хэд хэдэн төсөл дээр хамтран ажиллаж байна.

ЕХ-ноос Монголд хэрэгжүүлж байгаа

хөгжлийн хамтын ажиллагааны төслүүд

ЕХ болон түүний гишүүн орнуудын Монголд хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны төслийн нийт санхүүжилтийн багц (буцалтгүй тусламж, зээл) 2015 онд 190 сая евро давсан байна.



Боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд
€ 21.6 сая евро



Байгаль орчин, тогтвортой эрчим хүч
€ 95 сая евро



Уул уурхай, дэд бүтэц
€ 42 сая евро



Бизнесийн хөгжлийн дэмжлэг
€ 12.8 сая евро



Хөдөө нутгийн хөгжил
€ 3.6 сая евро



Засаглал ба иргэний нийгэм
€ 16.2 сая евро

Дараагийн бүлэгт ЕХ, түүний гишүүн орнуудын хэрэгжүүлж байгаа болон Европын Хөрөнгө Оруулалтын Банк (ЕІВ) зэрэг олон талт санхүүгийн байгууллагуудаар дамжин хэрэгжиж буй хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийн жишээг танилцуулж байна. Эдгээр төслүүд нь ЕХ-Монголын хамтын ажиллагааны эрч, амжилтыг тусган харуулахын зэрэгцээ ЕХ, гишүүн орнууд, Монгол Улс хамтын ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэрхэн хамтран ажиллаж байгааг харуулна. Төслүүдийг Монгол Улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сэдэвчилсэн зургаан салбараар бүлэглэн харуулав.



ЕХ ба түүний гишүүн орнууд

Хөгжлийн
хамтын
ажиллагааны
чиглэлүүд





Боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд

Сүүлийн үеийн тоо баримтаас харахад Монголын нийт хүн амын 98.3% нь бичиг үсэг тайлагдсан байгаа нь Азид хамгийн өндөрт тооцогдох үзүүлэлт юм. Эрүүл мэндийн хувьд, дундаж наслалт тогтвортой нэмэгдэж байгаа ч, эрүүл мэндийн зарим нэг ноцтой асуудлууд байсаар байгаа ба ялангуяа, элэгний хорт хавдраар өвчлөгсдийн тоо өндөр байгааг анхааралдаа авч шийдвэрлэх шаардлагатай. Мөн эмч, эрүүл мэндийн байгууллагууд хот суурин газруудад төвлөрсөн байдаг бөгөөд Монгол Улсын хүн ам тархан суурьшсан байдал нь боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн үр чадвартай, боловсон хүчний асуудлыг шийдвэрлэхэд улам бүр бэрхшээлтэй болгож байна. Монгол Улс мөн нүүдэлчдийн өвөрмөц соёлыг хадгалахын зэрэгцээ орчин үеийн шинэ чиг хандлага, өөрчлөлттэй хослуулах, археологийн хайгуулын талбар байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр зорьж байна.

"Боловсрол бол бидний ирээдүйн амжилтын хөрс юм. Би малчны гэр бүлээс Харвардын оюутан болсон. Монгол залууст маань ч ийм боломж байна."

Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн Элбэгдорж
2015 оны 6-р сарын 16-нд
Европын Парламентад
хэлсэн үгнээс...

ФРАНЦ | Эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагаа



Франц, Монгол хоёр улсын хот, мужуудын хоорондын түншлэл нь харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгоход дэм болсон. Үүний нэг жишээ нь Өвөрхангай аймаг, Алье мужийн (Овернь бүс) хөдөө нутгийн хамтын ажиллагаа бөгөөд энэхүү хамтын ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийн хэвлийн хөндий болон бусад дотор эрхтнийг дурандан шинжлэх чиглэлийн сургалтанд Монгол Улсаас 10 гаруй мэс заслын эмч Франц руу уригдсан. Эдгээрээс гурав нь Европын мэргэжлийн зэрэгтэй төгссөн. Францын засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Алье мужийн орон нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр эдгээр мэс заслын эмч нар одоо Монгол Улсад бусад эмч, сувилагч нарыг сургаж, Улаанбаатарт болоод Өвөрхангай зэрэг алслагдсан аймгуудад төрөхийн өмнөх бадараах эмчилгээний чанарыг сайжруулна. Мөн, Франц улс Улаанбаатар дахь клиникийн төв эмнэлэгт гэмтэл согог судлалын яаралтай тусламжийг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлсэн.

ИХ БРИТАНИ

Боловсрол, соёлын холбоо



Их Британийн Засгийн газрын санхүүжилтээр 2013-2016 онд эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт нийт 2.2 сая орчим еврогийн дүнтэй хоёр талт хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, нэр хүндтэй Chevening тэтгэлэгт хөтөлбөрөөр жил бүр 15 орчим Монгол оюутанд Их Британид магистрын боловсрол эзэмших боломж олгож, холбогдох бүх зардлыг даадаг. Мөн саяхан Монгол Улсын сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг шинэчилж, сайжруулах зорилгоор албаны хүмүүс Их Британид танилцах аялал хийж, туршлага судалсан.

Соёлын хамтын ажиллагааны хүрээнд Британийн армийн поло спортын баг Монголын армийн багийг Европ хэв маягын тоглолтонд бэлтгэхээр Монголын зүүн бүс нутагт нэг долоо хоног ажилласан. Үүний дараахан, Монголын баг Их Британийн Сэндхёрстэд нэг долоо хоногийн хугацаатай полоны сургалтад хамрагдав.

БЕЛЬГИ | Оношилгоо, эмчилгээг сайжруулах

Бельги Улс бүсийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр Монгол Улстай хамтран ажиллаж байна. Монголын зүүн аймгуудад өмнөх төслөө хэрэгжүүлсний дараа 2015 онд эхэлсэн төслийн хүрээнд, Бельгийн засгийн газар Монголын баруун хэсэгт орших Ховд аймаг дахь бүсийн эмнэлэгт эмчилгээний тоног төхөөрөмж авах, сургалт хийхэд зориулж 3.8 сая еврогийн санхүүгийн туслалцаа үзүүлж байна.

ЛЮКСЕМБУРГ

Зүрхний эрүүл мэндийг дээшлүүлэх

Люксембургийн санхүүжилттэй төслийн үр дүнд зүрх судасны эрүүл мэндийн зөвлөгөөг телевизээр авах сүлжээг Монгол орон даяар байгуулсан. Энэ сүлжээ нь 21 аймгийн улсын эмнэлгүүдийг нийслэлийн зүрх судасны эрүүл мэндийн мэдээллийн төвтэй холбож, эрүүл мэндийн зөвлөгөөг хамгийн алслагдсан аймаг, орон нутагт хүргэдэг боллоо. Улаанбаатар хот дахь Шастиний нэрэмжит Улсын 3 дугаар төв эмнэлэгт зүрхний мэс заслыг өдөрт нэг өвчтөнд буюу жилийн 250 өдөрт хийх боломжтой болсон. Мөн 8.3 сая еврогийн санхүүжилттэй төслийн хүрээнд аймгийн төвүүдэд төрөхийн өмнөх оношилгоо хийх, ахисан түвшний мэс заслын үр чадвар эзэмшүүлэх зэрэг шинэ үйлчилгээг нэвтрүүлснээр эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах чиглэлд томоохон ахиц гаргалаа.


“Улсын хэмжээний бүх эмнэлгийг холбосон телевизийн эмчилгээний сүлжээ нь мэдээллийн төвөөс шаардлагатай, чанартай зөвлөгөөг хамгийн алслагдсан аймаг орон нутагт ажиллаж буй эмч нарт цаг алдахгүй хүргэх боломжийг бүрдүүлсэн.”

Доктор Дагвын Мөнгөнчимэг
Шастиний нэрэмжит
улсын 3-р төв эмнэлгийн
Зүрх судасны тасгийн дарга

АВСТРИ | Нийгмийн салбаруудыг шинэчлэх

Австри улс 2011 оноос хойш Монгол Улс дахь олон нийтийн дэд бүтцийн хөгжилд түслалцаа үзүүлж байна. Энэ ажлын эхний хэсгийн хүрээнд, Монгол Улсын янз бүрийн түнш байгууллагуудтай хамтран ажиллаж 40 сая еврогийн санхүүжилт бүхий олон нийтийн салбарын төслүүдийг хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн салбарт Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Олон нийтэд үйлчлэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарыг сайжруулах зорилгоор 4 төсөл хэрэгжүүлж байна.

ЕХ | Чадварт суурилсан эдийн засаг



Монгол Улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын (МБС) тогтолцоонд хөрөнгө оруулалт хийснээр залуучуудын ажилгүйдэл, уул уурхай болон барилга зэрэг салбарууд дахь боловсон хүчний дутагдлын асуудлыг шийдвэрлэх алтан боломж гарсан. Энэ нь гадаадаас импортолсон мэргэжлийн ажиллах хүчнээс хамаарах Монгол Улсын хэт хамаарлыг бууруулж, Монголчуудын өөрсдийнх нь чадварт суурилсан, төрөлжсөн эдийн засгийг бий болгоход тусална.

ЕХ одоогийн байдлаар 6.5 сая еврогийн санхүүжилтээр энэ чиглэлийн 2 төслийг санхүүжүүлж байна. Орчин үеийн мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг одоогийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлж, төгссөн оюутнуудыг мэргэжлийн үр чадвар шаардсан ажилд бүрэн бэлтгэгдсэн байлгахын тулд Техник, Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Салбарыг Дэмжих I Төсөл нь Монгол Улсын засгийн газартай нягт хамтран ажиллаж байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн МСҮТ II төсөл нь Монгол Улсын эдийн засагт чухал нөлөөтэй хөдөө аж ахуйн салбарыг орхигдуулахгүй байхад голлон анхаарч байгаа бөгөөд ялангуяа, хөдөө нутгийн хөгжилд чухал нөлөөтэй хүнс, ногоо тариалалт болон мал аж ахуйн салбарт шаардлагатай үр чадварыг сургаж, эзэмшүүлэхийг зорьж байна.

ФРАНЦ | Археологийн салбар дахь хамтын ажиллагаа

Франц улс 1994 оноос хойш Монгол талын олон тооны археологийн малтлагын ажлуудыг дэмжин оролцсон бөгөөд эдгээрийн үр дүнд МЭ болон МЭӨ янз бүрийн цаг үед хамрагдах түүхэн баримт олдворуудыг амжилттай нээж илрүүлсэн юм. Гол Мод хавиас олдсон хааны хиргисүүр, Алтайн агуйн хадны сүг зураг мөн Сибирийн хил орчмоос олдсон 28 000 жилийн өмнөх гавлын яс нь Монголын газар нутгаас олдсон хамгийн эртний хүний үл мөр болсон зэрэг гайхам олдворуудыг нэрлэж болох юм. Франц, Монголын мэргэжилтнүүдийн 20 гаруй жилийн үр ашигтай хамтын ажиллагааны ачаар тус хоёр улс шинжлэх ухаан, тэр дундаа соёлын салбар дахь хамтын ажиллагаагаа бэхжүүлж чадсан.





Байгаль орчин, тогтвортой эрчим хүч

Монгол Улс байгаль орчин, эрчим хүчний олон тооны сорилттой тулгардаг. Ойн эзлэх талбай багасч, бэлчээрийн даац хэтэрснээс цөлжилт зэрэг цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг хурцатгаж байна. Сүүлийн 70 жилийн хугацаанд жилийн агаарын дундаж температур 2.14 °C-аар нэмэгдэж, хур тунадас нутгийн ихэнх хэсгүүдэд багассан. Монгол Улсын эрчим хүчний эрэлт хэрэгцээ жилд ойролцоогоор 8%-иар өсч байгаа тул, нөхцөл байдалд тохируулж, тогтвортой эрчим хүчийг бий болгох чиглэлд тодорхой ажлуудыг хийх нь чухал байна. Монгол Улсын хувьд малчдын (мөн бүх өрхийн) 75%-ийг 2030 он гэхэд баталгаатай эрчим хүчний эх үүсвэрээр хангах, усны хангамжийг сайжруулах, цаг уурын өөрчлөлтийг даван туулах улсынхаа чадварыг сайжруулах, хэд хэдэн салбарт ногоон технологийг нэвтрүүлэх, эмзэг экосистем, өвөрмөц биологийн олон янз байдлыг хамгаалах нь эн тэргүүнд шийдвэрлэх асуудлууд юм.

ГЕРМАН | Эрчим хүчний үр ашиг

Монгол Улсын нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд нь эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ арай чамай хангаж байгаагаас гадна ялангуяа, өвлийн улиралд агаарын бохирдлыг үлэмж нэмэгдүүлж байна. Германы санхүүжилттэй “Эрчим хүчний системийн үр ашиг” (ENEV) төсөл (3.9 сая евро) нь эрчим хүчний сүлжээгээ бүхэлд нь судалж шинжилж, эрчим хүчээ хэмнэхэд урамшуулал олгодог тохиромжтой тариф тогтооход нь зөвлөх замаар эрчим хүчний хэмнэлттэй стратеги боловсруулахад нь Монгол Улсад туслалцаа үзүүлдэг. Энэ төсөл нь мөн эрчим хүчний менежер, аудиторудыг бэлтгэхэд тусалдаг. Швейцарьтай хамтран санхүүжүүлсэн (3.8 сая евро) энэ хамтын ажиллагаа нь мөн сонгогдсон төрийн үйлчилгээний барилгуудын эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг сайжруулахад чиглэсэн.

Хөгжлийн албан ёсны тусламжийн (ODA) зээлүүдийн хажуугаар, ашиглалтын хугацааг нь уртасгаж, байгаль орчинд ээлтэй, баталгаатай, илүү аюулгүй цахилгаан, дулаанаар хангах зорилгоор Дарханы цахилгаан станц (10.5 сая евро) болон Улаанбаатарын 4-р цахилгаан станц (8.5 сая евро)-уудыг шинэчлэх ажлыг санхүүжүүлсэн.

“Германы засгийн газрын ачаар бид Дарханы цахилгаан станцын цахилгаан, дулаан үүсгэх үйл явцад байгаль орчинд ээлтэй хэлбэрээр томоохон шинэчлэл хийж чадсан. Ингэснээр, Дарханы бүсийн 90 000 орчим оршин суугч найдвартай, аюулгүй цахилгаан, дулааны хангамжтай болох боломжтой болно.”

н. Нямдаваа

Дарханы Дулааны цахилгаан станцын Ерөнхий захирал



ЕХ БА БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

Удаан эдэлгээтэй, тогтвортой барилга

ЕХ, Чехийн хамтран санхүүжүүлж, Caritas Czech Олон улсын байгууллагын хэрэгжүүлсэн төслөөр дамжуулан Монгол Улсын цахилгаан станцуудаас их хэмжээгээр ялгардаг хаягдал материал болох үнсийг ашиглан үнсэн орцтой барилгын материалын дотоодын зах зээлийг бий болгож чадсан. Дотоодын 20 орчим жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж (ЖДҮ) хуулийн дагуу энэ салбарт үйл ажиллагаа явуулж байна. Үнсэн орцтой бүтээгдэхүүний улсын стандарт батлагдаж Мэргэжлийн Боловсрол Сургалтын байгууллагууд тогтвортой барилгын практикийн талаар хичээлийн хөтөлбөртөө оруулсан. Харин дараагийн алхам бол үнэ цэнийн сүлжээнд оролцогчид буюу цахилгаан станцаас эхлээд барилгын салбарынхныг хүртэлх бүхий л талуудад барилгын тогтвортой үйлдвэрлэлийн үр ашгийг таниулах явдал юм.

“Хаягдал үнсийг ашигласнаар бид автоклавын хөнгөн бетоны үйлдвэрлэлийн нэг бүтэн процессыг алгасах боломжтой болсон. Ингэснээр өртгийг их хэмжээгээр хэмнэхээс гадна, нөөцөө үр дүнтэй ашиглахад тустай.”

Хатагтай Даваасүрэн

Түршилтаар үйлдвэрлэх төсөлд оролцсон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй “Дөлгөөн Барс” ХХК-ийн Ерөнхий техникч

Өндөр өсөлттэй байгаа Монголын барилгын салбарт цемент, ус болон бусад хольцуудаар хийсэн уламжлалт бетоныг их хэмжээгээр ашигладаг. Уламжлалт хольцуудыг хаягдал үнсээр орлуулснаар, барилгын салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд бетон үйлдвэрлэлийн зардлаа бууруулж, барилгын материалын дулаан тусгаарлах чадварыг сайжруулахаас гадна хаягдал үнсээ булах хэрэгцээ шаардлагыг бууруулах замаар цахилгаан станцуудад учирдаг санхүүгийн дарамтыг хөнгөлөх боломжтой. Монголд жил бүр нэг цахилгаан станц 300000 тонн хаягдал үнс үйлдвэрлэж байгаа нь байгаль орчны хувьд маш том аюул болж байна. Улаанбаатарын эргэн тойронд байрлах олон цахилгаан станц голын сав газартай ойр байрласан байдаг. Энэ чиглэлээр, EX SWITCH-Asia хөтөлбөрийн хүрээнд 1.4 сая еврогийн буцалтгүй тусламж олгосон.



ГЕРМАН | Монгол орны өвөрмөц биологийн олон янз байдлыг хамгаалах

Амьдрах орчны алдагдал, ой устан үгүй болох, бэлчээрийн хяналтгүй хэт ашиглалт болон цаг уурын өөрчлөлт зэрэг асуудал нь Монголын эмзэг экосистемд бодитоор заналхийлж байна. Германы хөгжлийн хамтын ажиллагаа бараг сүүлийн 25 жилийн турш Монголын өвөрмөц биологийн олон янз байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулсан. Герман улс нь үүр амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдал болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр бодлогын зөвлөмжийг бүсийн түвшинд хэрэгжиж байгаа техникийн болон зохион байгуулалтын инновациудтай хослуулдаг (ойролцоогоор 6 сая евро). Тэр дундаа, орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгохын сацуу ойн экосистемийг бэхжүүлэхийн тулд илүү тогтвортой ойн менежментийн практикийг тохируулан нэвтрүүлж, ойн ажилтнуудад мэргэшлийн сургалт хийх замаар Монголын ойн салбарт туслалцаа үзүүлж байна.



2011 оноос хойш Герман улс тусгай хамгаалалттай газар нутгуудын үр ашигтай менежментийн чиглэлд 11.5 сая еврогийн дэмжлэг үзүүлсэн. Холбогдох байгууллагууд тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс санхүүжилт хүсэх боломжтой. Энэхүү шинэлэг арга нь Монголын тусгай хамгаалалттай газруудын тогтолцоог бэхжүүлж, тодорхой экосистемүүдийн биологийн олон янз байдлыг хамгаалахаас гадна, дээрх бүс нутгийн ойролцоо амьдарч буй иргэдийн амьжиргааг сайжруулдаг.

ЕХ-ны гишүүн улсууд | Хамтарсан төслүүд

ЕХ-ны гишүүн улсууд хамтран төсөл хэрэгжүүлэх замаар хүчин чармайлтаа нэгтгэж болно. Тухайлбал, ойн нийт талбайг бууруулахгүй байх, гэмтэж, цөлжилтөд өртсөн газруудад нөхөн сэргээлт хийх зорилготой Монгол орны ойн болон орон нутгийн ой модны генийн сангийн хөгжил төслийг **БНЧУ** санхүүжүүлсэн.

ЕВРОПЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК Хот суурин газрын хүрээлэн буй орчныг сайжруулах

Европын Хөрөнгө Оруулалтын Банк (EIB) Азийн Хөгжлийн Банкны (ADB) санаачилж, боловсруулсан суурин газрын үйлчилгээг сайжруулах төслийн нэг хэсэг болох Улаанбаатар хотын гэр хорооллын усан хангамж, хаягдал ус, ариун цэврийн байгууламжид зориулан 50 сая еврогийн санхүүжилт хийж байна. Төслийн байгаль орчны ерөнхий үнэлгээ хийгдсэн ба Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам баталсан байна. Төслийн үр дүнд ард иргэдийг илүү чанартай ундны усаар хангаж, ус цэвэршүүлэх болон түгээх байгууламжуудын үр ашгийг сайжруулж, мөн хаягдал усыг дахин эргэлтэнд орохоос өмнө цуглуулж, цэвэршүүлэх замаар байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд эерэгээр нөлөөлнө. Энэ бол олон талт санхүүжилт хөгжилд хэрхэн далайцтай нөлөө үзүүлэх боломжтойг харуулах тод жишээ болж байна.



Уул уурхай, дэд бүтэц

Уул уурхайн салбарын огцом өсөлтийн үр дүнд Монгол Улс 2010 онд дэлхийд эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй орнуудын нэг болсон ч 2011, 2012 онуудад 15%-иас давж байсан энэ өсөлт тэр цагаас хойш үлэмж буурсан. Монгол Улс 2015 онд бага орлоготой орноос дунджаас дээш орлоготой орон болж ахисан ч дэд бүтцийн томоохон сорилтуудтай нүүр тулсан хэвээр байна. Гэлээ ч, урт хугацааны төлөв өөдрөг хэвээр байгаа юм. Дэлхийн хамгийн том зэсийн ордуудын нэг зэргээс бүрдсэн уул уурхайн салбарын 2 том төсөл хэрэгжсэнээр улсын нийт орлогын гуравны нэгийг бүрдүүлэх төлөвтэй байна. Олон Улсын Валютын Сан (ОУВС), Азийн Хөгжлийн Банк болон Дэлхийн Банк бүгд Монгол Улс байгалийн баялгаа ашиглах нь улсын хөгжилд эерэг нөлөөтэй гэж үзсэн.



БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

Аюулгүй ундны усыг хот суурин газруудад хүртээмжтэй болгох



Чехийн санхүүжилтээр усны хангамжийн системийг сайжруулах төслийг Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хэрэгжүүлснээр усны аюулгүйн стандартыг сайжруулж, ус хангамжийн дэд бүтэц нь хүн амын төлөвлөсөн өсөлтийг хангаж чадах хэмжээнд хүрсэн. Төслийн хүрээнд ус хангамжийн сүлжээг засварлаж, ус шахаж, түгээх автомат хяналтын системийг суурилуулж, орон нутгийн ус болон бохир усны байгууламжуудын чадавхийг сайжруулсан. Усны шинэ эх үүсвэр хайх ажил мөн хийгдсэн.



Чехийн засгийн газрын 845 000 еврогийн буцалтгүй тусламжаар хэрэгжсэн энэ санаачилга нь Монгол Улсын үндэсний хөгжлийн зорилтуудтай яв цав нийцэж байгаа юм. Монгол Улс 2011 онд нийт хүн амынхаа 85%-ийг илүү сайн чанарын ундны устай холбож, Мянганы хөгжлийн зорилтод тусгасан ундны усны зорилтдоо хүрсэн. Харин одоо Монгол Улс 2030 он гэхэд нийт хүн амаа НҮБ-ын тогтоосон стандартын дагуу усны ариун цэвэр, цэвэршүүлэлтийн наад захын шалгуурыг хангасан усаар хангахыг зорьж байна.

ГЕРМАН

Тогтвортой хөгжилд хүргэх байгалийн баялаг



Монгол Улс дэлхийд хамгийн их байгалийн баялагтай орнуудын нэгд тооцогддог ч, үүний үр ашгийг иргэн бүр хүртэж чадахгүй байна. Ашиглаагүй энэ нөөц бололцоогоо хүртээмжтэй өсөлт болгож, уул уурхайгаас бусад салбаруудыг хөгжүүлэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд Монгол Улсад техникийн экспертиз, нөөц шаардлагатай байна.

Үүнд хүрэхийн тулд, Герман улс одоогоор 4.9 сая еврогийн санхүүжилттэй байгаа Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлагыг (IMRI) саяхан эхлүүлсэн. IMRI нь Монголчуудын ажлын байрыг нэмэгдүүлж, орлогыг өсгөх уул уурхайд тулгуурласан тогтвортой, хүртээмжтэй эдийн засаг болон нийгмийн хөгжлийг бий болгоход тусалж байна. Энэ төсөл нь уул уурхайн бүс нутгуудын бүсийн тогтвортой хөгжил, байгалийн нөөцөд тулгуурласан зах зээлийн эдийн засгийн макро эдийн засгийн менежментэд тусалж байна.

Орон нутгийн түвшинд харвал, нутгийн хөгжлийн нэгдсэн түншлэлийн санаачлага нь нутгийн иргэд, бүс нутгийн захиргаа, орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд зэрэг олон оролцогч талуудыг нэгтгэж, эдийн засаг, нийгэм, улс төрийн яриа хэлэлцээ өрнүүлэх боломжийг бий болгосон. Германы болон олон улсын зөвлөхүүд Монголын түнш байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлж ялангуяа, олборлох аж үйлдвэрийн иж бүрэн гэрээ байгуулах чиглэлд анхаарч уг үйл ажиллагаанд оролцож байна. Монголын уул уурхайн компаниуд мөн компанийн нийгмийн хариуцлага (КНХ), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) болон жендер, хүний эрхийн асуудлуудын талаар илүү мэдлэгтэй болсон.

Холбооны Гео шинжлэх ухаан, ашигт малтмалын газар (BGR) нэмэлт түслалцаа үзүүлсэн. Нийт 2.8 сая еврогийн санхүүжилтийг бизнесийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, чанартай дэд бүтэц байгуулах, уул уурхайн хяналт шалгалт, уул уурхайтай холбоотой байгаль орчны хамгаалалтыг сайжруулах зэрэг мэргэжлийн чадавхийг сайжруулах тусгайлсан хөтөлбөрүүдэд зориулсан.

БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

Ашигт малтмалын нөөцийн газрын зургийг гаргах

Чехийн засгийн газрын санхүүжилтээр Ховд аймгийг газрын зурагжуулах төсөл хэрэгжүүлснээр хүн ам тархмал суурьшсан Баруун Монголын Алтайн уулсын байгалийн баялгийн нөөцийг илүү нарийвчилж үнэлж тогтоосон. Ингэснээр, тухайн бүс нутаг гадны хөрөнгө оруулалт болон дотоодын бизнес эрхлэгчдийн анхаарлыг татахаас гадна геологийн судалгааны салбар дахь Монгол, Чехийн түүхэн урт хугацааны хамтын ажиллагааг илэрхийлж байна.

Чехийн засгийн газрын 570 000 еврогийн буцалтгүй тусламжаар Чехийн Геологийн судалгааны байгууллагын хэрэгжүүлсэн энэ төсөл нь орон нутагт эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөдөөгийн ядуурлыг бууруулах Монгол Улсын эн тэргүүний зорилтуудтай мөн нийцэж байна. Үүнээс гадна, энэ төслийн хүрээнд Монгол болон Чех улсад сургалт зохион байгуулж орон нутгийн боловсон хүчнийг чадавхижуулсан.

ГЕРМАН | Уул уурхайн чадварыг хөгжүүлэх



2018 он гэхэд Монгол Улсын ашигт малтмалын салбарт багаар бодоход 40 000 техникийн мэргэжилтэн нэмж шаардагдана. Шинэ чадварлаг ажилчдын энэ эрэлт шаардлагыг чанар болон тоо хэмжээний хувьд хангах нь томоохон сорилт болж байна. Одоогоор улсын хэмжээнд их сургуулиудад ойролцоогоор 170 000 оюутан суралцаж байгаа бол мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд ердөө 45 000 оюутан бүртгэлтэй байна.



Тиймээс, Герман улс ашигт малтмалын салбарт мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх хамтарсан төсөлд 10.25 сая еврогийн тусалцаа үзүүлж, Швейцарь, Австрали улсуудтай нийлээд нийт 21.55 сая еврогоор хамтарч санхүүжүүлээд байна. Практик чадварт ихээхэн анхаарах мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Энэ сургалтын хөтөлбөрийг хамтран ажилладаг хэд хэдэн сургууль дээр

амжилттай хэрэгжүүлж, цахилгаан, аж үйлдвэрийн механик, халаалт, агааржуулалт, барилга угсралтын чиглэлээр техникчдийг бэлтгэсэн. Эдгээр төслийг хэрэгжүүлэхдээ сурсан зүйлсийг тогтвортой хадгалахын тулд ажлын байран дээр сургах системийг нэвтрүүлсэн. Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг татан оролцуулах нь мөн энэ төслийн нэг чухал хэсэг байв.

Үүнээс гадна, Герман улс Монголын ашигт малтмалын нөөцийн салбар, газрын тос боловсруулах үйлдвэрлэлд шаардагдах өндөр чадвартай инженер, технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэхээр шинээр байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд (GMIT) 4 сая еврогийн дэмжлэг үзүүлсэн. 2014 оны 9-р сараас хойш ашигт малтмалын нөөцийн инженер, механик инженер, байгаль орчны инженер мэргэжлээр бакалаврын зэрэг олгох 3 хөтөлбөр элсэлтээ авч эхэлсэн.



Бизнесийн хөгжлийн дэмжлэг

Монгол Улс илүү чадварлаг ажиллах хүчнийг бэлтгэх замаар уул уурхайн бүс салбарт ажлын байрны боломжийг бий болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхийн тулд зах зээл, үйлдвэрлэлийн ноу-хау бий болгохыг зорьж байна. Энэ нь тус улсын түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөх эрсдлийг бууруулах болон хотоос гадагшаа ажлын байр бий болгоход тусална. Мөн тус улсын газарзүйн байрлал гуравдагч орнуудад бүтээгдэхүүнээ экспортлоход бэрхшээл учруулдаг. ЕХ, гишүүн орнуудын хамт Монгол Улсын худалдааны гурав дахь том түнш болж байгаагийн хувьд мэдлэг, туршлага солилцох, боломжит шинэ зах зээлийг нээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Одоо хэрэгжиж буй Хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP+) хүрээнд Монголын бараа бүтээгдэхүүнүүд ЕХ руу үндсэндээ татваргүй нэвтрэх боломжтой.



ЕХ | Жижиг бизнесийг дэмжих

Эрч хүчтэй, бүтээлч, төрөлжсөн эдийн засгийг бий болгоход өрсөлдөх чадвар сайтай ЖДҮ онцгой хувь нэмэр оруулах учиртай тул Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (EBRD) хэрэгжүүлж байгаа төсөл энэ чиглэлээр түслалцаа үзүүлэхийг зорьсон. 60 сарын хугацаатай Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төсөл 2011 оны 8-р сард эхэлсэн ба ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах, мөн бизнесийн байгууллагуудын зүгээс ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг сайжруулах зорилгоор тэдний чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Макро түвшинд жижиг дунд бизнес эрхлэгчдэд худалдан авалтад оролцох боломж олгох, донор байгууллагуудын үйл ажиллагааны зураглал, хөрөнгө оруулалтын боломжуудын талаарх мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг бий болгосон. 2015 онд ЕХ ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Монголын эдийн засгийн төрөлжилтийг дэмжих төсөлд зориулан 9.3 сая еврогийн санхүүжилтийг баталсан. Энэ нь дээр дурьдсан төслийн хандлагын дараагийн үе шат болж, ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилт болон зөвлөгөө авах боломж олгох чиглэлд туслахад түлхүү анхаарах юм.



EX | Ур чадвар шаардсан тогтвортой ажлын байр




Сүүлийн жилүүдэд, зохистой ажлын байрны боломж хязгаарлагдмал байснаас шалтгаалан олон хүмүүс, тэр дундаа залуучууд, эмэгтэйчүүдийн хувьд ажлын байрны баталгаагүй, эмзэг байдал, бүрэн бүс хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн үүсэхэд хүрсэн байна. Шинэ ажлын байр бий болгож, бизнес эрхлэгч байгууллагуудыг дэмжсэнээр амьжиргааны нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулж, хот суурин газар руу шилжин суурьших тогтворгүй үзэгдлийг хязгаарлах боломжтой. Энэ бол ЕХ-ноос санхүүжүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлэх (SECIM)” төслийн гол зорилго юм.

Уг төсөлд ЕХ-ноос 8,2 сая еврогийн буцалтгүй тусламж олгосон бөгөөд үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газартай хувийн хэвшлийн инновацийг дэмжиж, хотоос гадна орчинд шинэ ажлын

байр бий болгоход дэмжлэг үзүүлэхэд холбогдох бодлогыг чиглүүлэх зорилгоор нягт хамтран ажиллаж байна. Энэхүү төсөл нь 2015 оны 6-р сард эхэлсэн бөгөөд 4 жилийн хугацаанд хэрэгжинэ. Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын хөдөө, орон нутгийн иргэдийн эдийн засгийн ирээдүйн хөгжлийг баталгаажуулахад чиглэсэн Монгол Улсын засгийн газрын Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой нийцэж байгаа юм.

УНГАР | Дэвшилтэт технологийн хөрөнгө оруулалт

2016 оны 1-р сард Унгар Улс, Монгол Улсын хооронд Сонгино дахь Биокомбинатыг шинэчлэн засварлах ажлыг санхүүжүүлэх 22 сая еврогийн зээлийн шугамын гэрээг байгуулсан. Энэ төслийг хэрэгжүүлснээр, Монголд Европын бараа үйлдвэрлэх шаардлагыг хангасан орчин үеийн биотехнологийн үйлдвэрийг байгуулах бөгөөд энэ нь Унгарын урт хугацааны түүхэн хамтын ажиллагааны илрэл болно. Анх 1974 онд Унгарын санхүү, техникийн тусламжаар баригдсан энэ үйлдвэрт бактери, вирусийн гаралтай вакцин, малын эмнэлгийн чиглэлийн бусад био бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг тул, ойролцоогоор 55 сая толгой малтай Монгол Улсын хувьд маш чухал юм.



АВСТРИ | Жижиг бизнест зориулсан зээл

Монголын ЖДҮ эрхлэгчид санхүүжилт татахад бэрхшээлүүдтэй тулгардаг нь бизнесийн хөгжилд тушаа болох эрсдэлтэй байдаг. Энэ асуудлыг шийдэхийн тулд, Австрийн хөгжлийн банк (ОеЕВ) бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Монголын Хас банкинд давуу эрхтэй 13 сая еврогийн зээл олгосон. Энэ санхүүжилт нь ажлын байрыг хадгалж, Монголын эдийн засгийг дэмжихэд тустай.

EX | Олон улсын стандартуудыг тогтоох

Монгол Улсын гадаад бодлогын том зорилтуудын нэг нь бараа бүтээгдэхүүнээ чөлөөтэй экспортлохтой холбоотой Европын зарчим, норм, стандартуудыг нутагшуулах тухай Монгол Улсын үүрэг амлалт юм. Энэ нь Монгол Улсад эдийн засгаа төрөлжүүлж, шинэ зорилтот зах зээлд гарах боломжуудыг бий болгож, гадаадад Монголын бизнес эрхлэгчдэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. EX-ноос санхүүжүүлж, Их Британийн Стандартын байгууллага (BSI) EX-ны гишүүн орнуудын (БНЧУ, Испани, Мальт) мэргэшсэн байгууллагуудтай хамтран 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” төслийн (SMMSS) хүрээнд мэдлэг чадвар, тэргүүн туршлага дамжуулах чиглэлээр үнэтэй туслалцаа үзүүлж байна. Энэ төслөөр дамжуулан Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ) EX-ны гишүүн орнуудтай урт хугацаанд хамтран ажиллах боломжтой болсон.

Экспортын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүнүүдийг тодорхойлж, хэрэгжих боломжтой экспортын стратегийг боловсруулах зорилгоор Засгийн газар, бизнес эрхлэгчид, ажил олгогчид болон судалгаа шинжилгээний байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн Үндэсний чанарын ажлын хэсгийг байгуулсан. Төслийн зүгээс Засгийн газрын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, бүтээгдэхүүний баталгаажуулалт зэрэг асуудлаар EX-ны гол хууль дүрмүүдтэй Монгол Улсын хууль эрх зүйн орчинг нийцүүлэх Стандарчиллын хуулийн шинэ төслийг боловсрууллаа. Цаашид иргэний эрх, эрүүл мэндийг баталгаажуулах зорилгоор EX-ны зарчмуудыг нэмж тусгасан. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон Бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулиудын төслийг боловсруулах болно. Түүнчлэн, 1500 гаруй төрийн албан хаагчийг Дэлхийн худалдааны байгууллагын (ДХБ) Мэдээлэл лавлагаа, хилийн хорио, цээрийн хяналт шалгалт зэрэг сэдвийг хамарсан сургалт зохион байгуулсан. EX-ны 4 сая орчим еврогийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа SMMSS төсөл 2017 оны 4 сард тайлангаа тавина.



“Энэ төсөл нь хэрэглэгчийн харилцан итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Жишээ нь, Өмнөд Солонгосын иргэн органик Монгол мах худалдаж авахыг хүсвэл, энэ нь органик бөгөөд ямар нэгэн эмийн үлдэгдэл агуулаагүй гэдэгт итгэлтэй байх шаардлагатай. Бидний хийж буй зүйл бол, Монголчууд өөрсдөө махаа органик гэдгийг батлах зорилгоор сорилт туршилтаа өөрсдөө хийдэг, түүнийгээ баталгаажуулдаг боломжийг олгох явдал юм. Ингэснээр худалдаан дахь харилцан итгэлцэл бий болж, цаашилбал хэрэглэгчид үүнээс үр ашгаа хүртэх болно.”

Хэнк Дэ Пау

SMMSS төслийн багийн ахлагч



Хөдөө нутгийн хөгжил

Хөдөө аж ахуйн бол уул уурхайн салбарын дараа орох Монголын эдийн засгийн хоёр дахь том салбар бөгөөд мал аж ахуй нь улсын экспортын нийт орлогын бараг 10%-ийг дангаараа бүрдүүлж, улсын нийт ажиллах хүчний 35%-ийг ажлын байраар хангаж байна. Монгол Улсын хөдөө, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд зах зээлийн эрэлтэд суурилсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, болон мах, цагаан идээн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэсэн зорилтууд багтдаг. Засгийн газар орон нутгийн иргэдийг өөрсдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд илүү оролцоо өндөртэй байхыг уриалж байна. Хөдөө орон нутагт илүү олон ажлын байр бий болгох нь хот суурин газар руу, ялангуяа хахир хүйтэн өвлийн дараа нэмэгддэг хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг бууруулахаас гадна, Монгол Улсын үндсэн зорилт болох эдийн засгийн төрөлжүүлэлтэд тус нэмэр болох юм.



ФРАНЦ | Брэнд бүтээхүй

Франц улс 1935 оноос хойш газарзүйн заалтыг (GIs) хэрэглэн үндэсний бүтээгдэхүүнээ хамгаалж ирсэн туршлагатай бөгөөд Монголчуудад энэ тал дээр нь мөн туслалцаа үзүүлж байна. Газарзүйн заалт нь чанар, нэр хүнд бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг газар нутагтай нь холбох онцлог тэмдэгтүүд бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар зах зээл дээр байгаа ийм бүтээгдэхүүнүүдийг бусдаас ялгах, танихад, тусалдаг. Францчуудын туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа энэ хамтын ажиллагааны том нэг жишээ нь Монголын

Увсын чацарганыг ЕХ-нд бүртгүүлэх явдал юм. Увс аймгийн байгалийн хатуу, ширүүн уур амьсгалд ургадаг энэ зэрлэг жимсэн дэх Омега 3, Омега 6 болон бусад амин дэмийн агууламж ихтэй тул Монголчуудад өндрөөр үнэлэгддэг.



Газарзүйн заалт гэдэг нь орон нутгийн хөгжлийг дэмжих маш чухал хэрэгсэл бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн газар нутгийн онцлогоос хамаарч чанар нь тодорхойлогдож байдаг тул, үйлдвэрлэлийн газрыг нь өөрчлөх боломжгүй байдаг. Францын Хөдөө аж ахуйн яам Монголын оюуны өмчийн газрын ажиллагсадад зориулж жил бүр Европт сургалт зохион байгуулдаг бөгөөд газар зүйн заалтын тухай семинарыг мөн улсын хэмжээнд тогтмол зохион байгуулдаг. Монгол, Франц хоёр орны хамтын ажиллагааны гол салбаруудын нэг нь эрчим хүчнээс гадна хөдөө аж ахуйн салбарын бизнес юм.



БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

Хөдөө орон нутгийн бүтээмжийг дээшлүүлэх

Чехийн засгийн газрын санхүүжилттэй, Монголын мал сүргийн чанарыг сайжруулах төсөл нь хөдөө орон нутгийн орлогыг нэмэгдүүлж, малчдын аюулгүй байдлыг улам дээшлүүлэхэд зориулагдсан. 340 000 еврогийн санхүүжилттэй энэ төсөл нь өмнөх 2 төслийн үргэлжлэл бөгөөд нутгийн иргэдийг мал эрлийзжүүлэх шинэ технологитой танилцуулж, мал сүргийн чанарыг сайжруулах зорилгоор үр тогтоох илүү үр ашигтай системийг бий болгоход тусалсан. Монголд малын зохиомол хээлтүүлгийн үр ашгийг нэмэгдүүлэх нь хэмээх 2 жилийн хугацаатай хэрэгжсэн энэ төсөл Монголын хамгийн том 3 хотод (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт) цагаан идээ нийлүүлдэг малчдад голчлон төвлөрсөн.

Мал аж ахуй бол Монгол Улсын нийт экспортын бараг 10%, нийт ажиллах хүчний 35%-ийг бүрдүүлж байгаа их чухал салбар юм. Мал аж ахуйн тодорхой техникүүдийг шинэчлэх замаар бүтээмжийг сайжруулах нь улсын хүн амын үнэмлэхүй хэсэгт мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлж болох юм. Цаашлаад, хөдөөгийн амьдралын зарим хэв маягийг орчин үеийн жишигт нийцүүлж өөрчилснөөр, бэлчээр талхлагдах, газрын үр шим буурах мөн урт, хүйтэн өвлийн улиралд олон тооны мал хорогдох зэрэг байгаль, цаг уурын олон хохирлыг бууруулахад тустай байж болно.

БОЛГАР

Хөдөө аж ахуйн салбар дахь техникийн хамтын ажиллагаа

2015 онд Болгар Улс Монгол Улсад хөдөө аж ахуйн салбарт хөгжлийн албан ёсны тусламж үзүүлэх нийт 1.8 сая еврогийн санхүүжилттэй төслийн 2 баримт бичигт гарын үсэг зурсан. Нэг гэрээгээр нь Монгол оюутнууд Болгарын их сургуулиудад хөдөө аж ахуйн чиглэлээр суралцах боломж олгосон бол, нөгөө гэрээгээр хүлэмж барихад техникийн туслалцаа үзүүлэхээр болсон. Эдгээр гэрээнүүд нь ажилтнуудын чадавхийг дээшлүүлж, бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх замаар Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих зорилготой.



ЕХ БА ФРАНЦ | Тогтвортой ноолуур

Ноолуур нь Монголын малчдад тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгож, амьдралынх нь нэг хэсэг болохын дээр хилийн чанадад Монголын нэр хүндийг өргөх өндөр чанартай бүтээгдэхүүн болдгийн хувьд эдийн засгийн болон соёлын маш их ач холбогдолтой бүтээгдэхүүн юм. Гэсэн ч, хөдөө орон нутгийн үйлдвэрлэгчид хэд хэдэн сорилттой нүүр тулж байна. Бэлчээр ихэд талхлагдсанаас шалтгаалж, бэлчээрийн нийт талбайн 70% орчмынх нь даац хэтэрсэн, мал сүргийн тоо хэт тогтворгүй нэмэгдсэн, түүхий ноолуур зэрэг хөдөө аж ахуйн боловсруулаагүй түүхий эдийг голчлон Хятад руу маш хямд үнээр гаргаж, тэнд нь боловсруулж байна. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд, ЕХ-ны санхүүжүүлж буй төсөл нь хөдөө орон нутгийн алслагдсан хэсгүүдийг экспортын шинэ зах зээлтэй холбож, бэлчээрийн хамтын менежмент, малын удам сайжруулах зэрэг тогтвортой арга механизмуудыг хэрэгжүүлэх зорилт тавьсан билээ.

ЕХ-ны 450 000 еврогийн санхүүжилттэй, Agronomes et Vétérinaires Sans Frontières (AVSF)-ийн хэрэгжүүлж байгаа энэ төсөл нь Баянхонгор аймгийн 2 сумын малчдын холбоод, малчдын хоршоод болон бэлчээр ашигладаг бүлгүүдтэй хамтран малын бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлж, малын тоо толгойг бууруулах, самнаж боловсруулсан ноолуур экспортлох чиглэлээр ажиллаж байна. Эдгээр түршлагыг нэвтрүүлсэнээр малчдын зах зээлийн төлөв байдлыг сайжруулах болно. Хоршооны засаглал, чанарын хяналт, маркетинг зэрэг чиглэлээр хоршооны гишүүн малчдыг сургаж, ноолуурын агуулахуудыг барьсан.

Мөн хоршоо бүрт тохирох бизнесийн төлөвлөгөөг боловсруулж байна. Европын тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид сайн чанарын, самнасан монгол ноолуурыг худалдан авах эерэг хандлагатай байгаагаас харахад, энэ төсөл нь гадаадад монгол ноолуурын талаархи ойлголтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. “Өртгийн сүлжээ” хэмээх энэ ойлголтыг Монгол орны бусад газруудад авч ашиглана гэж найдаж байна.



Засаглал ба иргэний нийгэм

Монгол Улс нь ардчилсан тогтолцоот цөөн улс бүхий бүсэд ардчилсан нийгмийг байгуулж, бэхжүүлж чадсан үлгэр жишээ орон юм. Ардчиллыг хөгжүүлсэн 20 гаруй жилийн хугацаанд Монгол Улс Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын (OSCE) гишүүн орноор хүлээн зөвшөөрөгдөж, хоёр жилийн турш Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг амжилттай даргалсан. Монгол Улс цаашид ардчилсан тогтолцоогоо улам бэхжүүлэх, Европын норм, стандартууд болон засаглалын тэргүүн туршлагыг нэвтрүүлэхийг зорьж байна. Энэ нь нийгмийн бодлогод нөлөөлж, урьдчилан таамаглах боломжтой бөгөөд тогтвортой хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлэхэд ач холбогдолтой. Хүчирхэг ТББ нь ил тод байдал болон шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангахад чухал нөлөөтэй.



НИДЕРЛАНД

Дипломат харилцаа

Нидерланд улс нь Клингендэйл Дипломат Академидаа олон жилийн турш Монголын дипломатчдыг бэлтгэх сургалт зохион байгуулж байна. Ирээдүйн дипломатчдад сайн засаглалын талаар тэргүүлэх судлаачид, мэргэжилтнүүд болон сэтгэгчдээс суралцах боломж олгодог хоёр талын уг хөтөлбөрт Монголоос нийт 80 хүн хамрагдаад байна. Сүүлийн сургалтууд нь Монголын урт хугацааны зорилтод голлох үүрэгтэй дипломат ёс, тогтвортой байдал, хөгжил гэсэн үндсэн 3 сэдэвт төвлөрсөн.





EX | Сайн засаглалд суурилсан өсөлт

Эх орныхоо байгалийн асар их нөөц баялгаас бүх Монголчууддаа ашиг тус хүртээхийн тулд, орлого болон татварын төлөв тооцоог бодитойгоор үнэлж дүгнэдэг, мөн баялгийг тэгш хуваарилдаг илүү үр дүнтэй арга хэрэгслийг бий болгох хэрэгтэй байна. Энэ бол Монголын бодлого тодорхойлогчдыг огцом өсөлт, огцом уналтын хооронд савладаг загвараас бүгдэд, тэр дундаа хамгийн эмзэг бүлэгт үр шимээ өгдөг хөгжлийн тогтвортой загварыг бий болгоход дэм болох EX-ны санхүүжүүлж байгаа Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал (EG4EG) төслийн гол зорилт юм.

2015 оны 2-р сард эхэлсэн, EX-ны буцалтгүй түслэмжийн хүрээнд хэрэгжиж буй 3.5 сая еврогийн төсөв бүхий энэ төсөл нь тэгш хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн бодлого, дэд бүтцийг бий болгоход шаардлага бүхий бодлого, стратеги төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Монгол Улсын Сангийн яамтай нягт хамтран ажиллаж байна. Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал (EG4EG) төслийн түншүүд нийгмийн хамгааллын үйлчилгээг үр дүнтэй хүргэх чадавхийг бий болгох чиглэлээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай мөн нягт хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монголд өвөл хүндэрч, зуд болох үед малчид, тариаланчид амь зуулгаа алдах эрсдэлтэй учирдаг. Тиймээс, үр дүнтэй нийгмийн хамгаалал хүн бүрт хүртээмжтэй байх нь чухал. Төсөл үндсэндээ Монгол Улс тогтвортой, тэгш өсөлтийн үндсэн зорилтдоо хүрэхэд туслах зорилготой юм.



EX | Хүний наймаатай тэмцэх

Монгол Улсын өмнөд хэсгийн уул уурхайд тулгуурласан аймаг, сумдыг зорих дотоодын шилжин суурьшигчдын урсгал нэмэгдсэний дотор ялангуяа, эмэгтэйчүүд хүний наймаа, бэлгийн мөлжлөг болон жендерт тулгуурласан хүчирхийллийн хохирогч болох эрсдэл өндөр байна. Хүний наймааны эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахын тулд, эмэгтэйчүүдэд өөрсдийн бизнесийг эхлүүлэхийг дэмжиж, хүний наймааны хохирогч болсон нь тогтоогдсон эмэгтэйчүүдэд шууд туслалцаа үзүүлэхээр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM) орон нутгийн иргэний нийгмийн 2 байгууллагатай хамтран EX-ны санхүүжилттэй төслийг хэрэгжүүлсэн.

Одоогоор, бизнес эрхлэх сонирхолтой, бизнесийн санаагаа олсон шилжин суурьшигч 50 эмэгтэй бизнесийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр сургалтанд хамрагдаад байна. Тэдний дундаас бизнес төлөвлөгөө нь хэрэгжээд амжилтанд хүрэх боломжтой 20 эмэгтэйд бизнесийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх анхны дэмжлэгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгоод байна. Мөн, төслийн хүрээнд хүний наймааны хохирогчдод зөвлөх үйлчилгээ, хууль эрхзүйн дэмжлэг, эрүүл мэндийн үзлэг хийх хэлбэрээр тусламж үзүүлсэн. Цаашлаад, Өмнөговь аймгийн захиргааны 50 орчим ажилтан шилжиж ирсэн иргэдэд үзүүлэх шаардлагатай нийгмийн үйлчилгээг сайжруулж бэхжүүлэх чиглэлээр сургалтанд хамрагдсан.



ИХ БРИТАНИ | Засаглалыг сайжруулах хоёр талын харилцаа



Их Британи засаглалыг сайжруулж, иргэний нийгмийн үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр хоёр талын хамтарсан хэд хэдэн төслийг эхлүүлсэн. 2016, 2017 оны сонгуулийн үеэр Монголын төрийн байгууллагууд болон ТББ-ын тавих хяналт, ил тод байдлыг дэмжихэд чиглэсэн нэг санаачлагыг жишээ болгон авч болох юм. Нөгөө төсөл нь сонгуульд оролцох оролцоог нэмэгдүүлэхийн тулд, Монголын залуучуудын дунд ардчиллын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Мөн, Их Британийн элчин сайдын яам 2015 оны 10-р сард Норвегийн Лиллехамер хотод болсон Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн бага хуралд Монголын хэвлэлийн хүрээлэнгийн төлөөллийг оролцуулж, сургалтад хамруулах замаар тус байгууллагын чадавхийг сайжруулах санаачлага хэрэгжүүлсэн.



ЕХ-ны гишүүн орнуудын Монгол Улс дахь төлөөлөл

	Австри	☎ (+86) (10) 65 32 98 69	✉ peking-ob@bmeia.gv.at
	Бельги	☎ (+86) (10) 65 32 17 36	✉ beijing@diplombel.fed.be
	Болгар	☎ (+976) (70) 140 403	✉ Embassy.UlanBator@mfa.bg
	Хорват	☎ (+86) (10) 65 32 62 41	✉ croemb.beijing@mvep.hr
	Кипр	☎ (+86) (10) 65 32 50 57/59	✉ beijingembassy@mfa.gov.cy
	Бүгд Найрамдах Чех Улс	☎ (+976) (11) 321 886 (+976) (11) 311 053	✉ epodatelna@mzv.cz
	Дани	☎ (+86) (10) 85 32 99 00	✉ bjsamb@um.dk
	Эстони	☎ (+86) (10) 85 31 67 00	✉ embassy.beijing@mfa.ee
	Финлянд	☎ (+86) (10) 85 19 83 00	✉ sanomat.pek@formin.fi
	Франц	☎ (+976) (11) 324 519	✉ contact@ambafrance-mn.org
	Герман	☎ (+976) (11) 323 325 (+976) (11) 320 908	✉ info@ulandiplo.de
	Грек	☎ (+86) (10) 85 32 54 93	✉ gremb.pek@mfa.gr
	Унгар	☎ (+976) (77) 005 600	✉ missionuln@mfa.gov.hu
	Ирланд	☎ (+86) (10) 85 31 62 00	✉ beijing@dfa.ie
	Итали	☎ (+86) (10) 85 32 76 00	✉ consolare.pechino@esteri.it
	Латви	☎ (+86) (10) 64 33 38 63	✉ embassy.china@mfa.gov.lv
	Литва	☎ (+86) (10) 84 51 85 20	✉ amb.cn@urm.lt
	Люксембург	☎ (+86) (10) 85 88 09 00	✉ pekin.amb@mae.etat.lu
	Мальт	☎ (+86) (10) 65 32 31 14	✉ maltaembassy.beijing@gov.mt
	Нидерланд	☎ (+86) (10) 85 32 02 00	✉ PEK-Mongolia@minbuzan.nl
	Польш	☎ (+48) (79) 555 05 83	✉ ulanbator.amb.sekretariat@msz.gov.pl
	Португал	☎ (+86) (10) 65 32 32 20	✉ pequim@mne.pt
	Румын	☎ (+86) (10) 65 32 34 42	✉ beijing@mae.ro
	Словак	☎ (+86) (10) 65 32 15 30/31	✉ emb.beijing@mzv.sk
	Словени	☎ (+86) (10) 64 68 10 30/11 54	✉ sloembassy.beijing@gov.si
	Испани	☎ (+86) (10) 65 32 36 29	✉ emb.pekin@maec.es
	Швед	☎ (+86) (10) 65 32 97 90	✉ ambassaden.peking@gov.se
	Их Британи	☎ (+976) (11) 458 133	✉ Enquiries.Mongolia@fco.gov.uk

ЕХ-НЫ ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛУУДЫГ ХЭРХЭН ОЛЖ АВАХ ВЭ?

Үнэгүй хэвлэмэл материалууд:

- Нэг хувийг:
ЕХ-ны номын дэлгүүрээс авна (<http://bookshop.europa.eu>);
- Нэгээс дээш хувь эсвэл танилцуулга/газрын зургийг:
Европын Холбооны төлөөлөгчийн газраас (http://ec.europa.eu/represent_en.htm);
ЕХ-ны гишүүн бүс орнууд дахь төлөөлөгчийн газраас
(http://eeas.europa.eu/delegations/index_en.htm);
Europe Direct үйлчилгээнд холбогдон авч болно.
(http://europa.eu/europedirect/index_en.htm) эсвэл
00 800 6 7 8 9 10 11 дугаарт холбогдож (ЕХ-ны нутаг
дэвсгэрээс үнэгүй холбогдоно) (*).

(*) Мэдээллүүд үнэгүй, ихэнх утасны дуудлагатай адил (зарим утасны операторууд,
утасны бүхээг, зочид буудлууд дуудлага хийхэд танаас төлбөр авч магадгүй).

Төлбөртэй хэвлэмэл материалууд:

- ЕХ-ны номын дэлгүүрээс авна (<http://bookshop.europa.eu>).

Зургийн зохиогчийн эрх

Доор нэр дурдагдсан эх сурвалжаас авсан зургуудаас бусад гэрэл зургийг танилцуулгад дурдагдсан янз бүрийн төслүүдээс авсан: Хуудас 3: © Aleksandr Hunta/Shutterstock | Хуудас 4: © Peter Ptschedlinzew/Getty Image | Хуудас 5: © Tomohiro Ohsumi/Bloomberg via Getty Images (их цургууль) | © Alenvi/Shutterstock (Улаанбаатар) | © Timothy Allen/Getty Images (хүүхэд) | © EBRD (ажилчин) | © Totajla/Shutterstock (байгалийн зүрэг) | Хуудас 9: © Thomas Koehler/Getty Images | Хуудас 19: © Mark Agnor/Shutterstock | Хуудас 20: © FAO | Хуудас 22: © Kostrez/Shutterstock (жимс) | © Sean Gallagher/FAO (зах) | Хуудас 24: © Pearly-Jacob/AVSF | Хуудас 27: © Frederic J. Brown/AFP (UK)



Европын Холбооноос Монгол Улсад хавсран суугаа Төлөөлөгчийн Газар

15 Донжигменвай Дажие, Санлитун, 100600, Бээжин

Утас: (+86) (10) 84 54 80 00

Факс: (+86) (10) 84 54 80 11

Цахим шуудан: delegation-china-mongolia@eeas.europa.eu

Вэбсайт: <http://eeas.europa.eu/delegations/mongolia/>

<http://eeas.europa.eu/delegations/china/>

Нэмэлт мэдээлэл авах бол

- Хөгжил, хамтын ажиллагаа – EuropeAid:
http://ec.europa.eu/europeaid/index_en.htm
- Capacity4dev.eu – хөгжлийн хамтын нийгэмлэгтэй холбох:
<http://capacity4dev.ec.europa.eu>
- Европын Гадаад Харилцааны Алба:
http://eeas.europa.eu/index_en.htm
- Хүмүүнлэгийн туслалцаа, иргэний хамгаалалт:
http://ec.europa.eu/echo/index_en.htm
- Европын Холбооны талаар асуулт байна уу?
Europe Direct танд туслах боломжтой: 00 800 6 7 8 9 10 11
<http://europedirect.europa.eu>

